



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 07 өдөр

Дугаар 4/44

Дэлгэрхаан сум

**Мал амьтны сэг зэм устгал, орчны
халдваргүйтгэлийн ажлыг зохион
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1, 7.3.2, 7.3.3, 7.3.4, 7.3.6 дахь заалтууд, Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/181 захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Мал амьтны сэг хүн, малын халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор сэг зэм цуглуулж устгах орчны халдваргүйтгэл хийх ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 01-ныг хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2. Мал амьтны сэг зэм устгал орчны халдваргүйтгэлийг мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон журам зааврын дагуу иргэд, малчид, нөхөрлөлийн оролцоотой зохион байгуулж ажиллахыг 1,2,3,4,5 багийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Сэг зэм устгасан талбай, мал, амьтан үхсэн хашаа, байр, худаг, уст цэг, гол, булаг шанд, бэлчээрийн орчныг халдваргүйтгэх ажлыг хийж гүйцэтгэхийг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн захирал, малын эмч (Ч.Хоролмаа), (О.Батболд), (С.Сарантуяа) нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд, хяналт тавьж, шаардлагатай халдваргүйтгэлийн бодис, хамгаалах хувцас хэрэгсэл, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр ханган, гүйцэтгэлийг хянаж шалгах, үр дүнг танилцуулахыг мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (Д.Баярмаа), байгаль орчны хяналтын улсын байцаагч (У.Ариунтуяа), хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Д.Батнасан)-нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Б.ЭНХ-АМГАЛАН

